



**БОГД БАНК**  
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2023

4-Р УЛИРЛЫН ТАЙЛАН



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



## НОГООН ОРЧИН I

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Монголын банкны холбооны санаачилгаар арилжааны банкнууд хамтран Монголбанкны дэмжлэгтэйгээр Тэрбум мод санг байгуулж, анхны төслийн нээлттэй сонгон шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг өнгөрсөн 5 сард зарласан билээ.

Уг төслийн 3-р чиглэлийн хүрээнд буюу МУИС-ийн Экологийн боловсролын төвийн “Амьд байгалийг аль ч цагт” төслийн нээлтэд БОГД БАНК оролцлоо. МУИС-ийн Экологийн боловсролын төвийн хамт олон сүүлийн 6 сарын хугацаанд хүүхэд багачуудад ойн экосистемийн талаар мэдлэг олгох зорилгоор “Ой яг...” өртөөг бий болгон танхимын тохижилт цоо шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулан ажиллаж танилцуулж байна.

Энэхүү төслөөр бид хүүхэд залуучуудын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, олон нийтэд тогтвортой хөгжлийн мэдлэг, экологийн боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч, сурагч, эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт нэмэгдүүлж, цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх арвин үйлсэд арилжааны банкнууд хамтран хувь нэмрээ оруулж байгаадаа таатай байна.

Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл, түүний эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөлөл нэмэгдэж, эдийн засгийн тогтвортой өсөлтөд эрсдэл учирч байгаа энэ үед нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр Монголын банкны холбооноос зохион байгуулдаг нэгдсэн мод тарих аян болон өөрсдийн төгөлд мод тарьж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үйл ажиллагааг дэмжин ажилласаар байна.



## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Богд банк нь Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд ТоС холбоо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран шалгаруулдаг "Жендерийн Манлай байгууллага" шалгаруулалтад оролцлоо. Бид "Байгаль, орчин, нийгмийн хариуцлага, жендерийн эрх тэгш байдлын бодлого"-доо анх удаа Жендерийн эрх тэгш байдлын бодлогыг дэлгэрэнгүй тусгасныхаа хүрээнд энэхүү шалгаруулалтад оролцсон. Банк нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан бүх бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйл ажиллагаандаа жендерийн эрх тэгш байдлын бодлогыг баримтлан ажиллаж байна. Банк нь үйл ажиллагааныхаа зарчмын хүрээнд банкны, салбарын, үндэсний, олон улсын түвшинд ажиллан явуулж байна. Бид гадагшаа болон дотогшоо чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

2024 ондоо бид тогтвортой санхүүжилтийн хүрээнд "Жендер болон эмэгтэйчүүд" чиглэсэн үйл ажиллагаандаа, санхүүгийн салбарын "Уур амьсгалын өөрчлөлт"-ийн салбарт үзүүлэх нөлөөллийн бууруулахад чиглэсэн арга хэмжээнд ажиллах болно.


**БОГД БАНК**  
 ХҮВЬЦААТ КОМПАНИ

**БОГД БАНК**  
 ХҮВЬЦААТ КОМПАНИ

**2023 ОНЫ**  
**"ЖЕНДЭРИЙН МАНЛАЙ БАЙГУУЛЛАГА"-ЫН**  
**ШАЛГАРУУЛАЛТАД ЗОРИУЛСАН ТАЙЛАН**



**БОГД БАНК ХК** - ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

БХГ-Эко албаны  
 Тогтвортой санхүүжилт хариуцсан мэргэжилтэн  
 М. Дэлгэрмөрөн



Карьер өсөлт  
Хөгжил, дэвшил



Боломжийг олгох,  
гаргаж өгөх



Бизнес эрхлэгч  
эмэгтэйчүүдийг  
дэмжих



Уян хатан ажлын  
байр

## НОГООН САНХҮҮЖИЛТ

Бид тайлант хугацаанд НОГООН зээлийг санхүүжүүлэх болон жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор гадаадын Enabling Capital хөрөнгө оруулалтын сан АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацаас (DFC) санхүүжилт амжилттай дахин татсан.


**BOGD BANK**  
 JOINT STOCK COMPANY


**DFC** U.S. International  
 Development  
 Finance Corporation

Bogd Bank successfully signed a  
**USD 15 million**  
 Financing Agreement with DFC


**BOGD BANK**  
 PUBLIC JOINT - STOCK COMPANY


**EQ**  
 Enabling  
 Capital

SUCCESSFULLY RECEIVED FUNDING FROM  
**ENABLING CAPITAL**  
 IMPACT INVESTMENT ADVISORY COMPANY